



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Батсүх

Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв
 - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН,
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАДАРЧ ТАНАА

2026.02.12 № УВА-2026/135/НА-СТА-7шЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050222

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,472,155.00	75,463,005.00
33	Авлага	0.00	635,000.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	0.00	635,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,472,155.00	74,828,005.00
351	Түүхий эд материал	22,612,005.00	44,599,105.00
35110	Тусгай зориулалттай материал	22,612,005.00	44,599,105.00
354	Хангамжийн материал	29,860,150.00	30,228,900.00
35410	Бичиг хэргийн материал	1,272,300.00	929,350.00
35420	Аж ахуйн материал	14,325,300.00	13,636,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,215,500.00	4,215,500.00
35470	Бусад хангамжийн материал	10,047,050.00	11,448,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,479,878,912.49	2,367,336,732.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,479,878,912.49	2,367,336,732.52
392	Биет хөрөнгө	2,162,885,579.05	2,050,555,065.64
39201	Барилга, байгууламж	2,119,604,502.00	2,119,604,502.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-552,572,752.78	-608,763,573.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,700,000.00	74,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-56,229,166.68	-68,679,166.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	382,354,284.00	307,025,824.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-236,898,019.52	-180,065,026.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,522,054.90	100,398,027.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,595,322.87	-52,665,521.29
39213	Түүх соёлын дурсгалт зүйл	359,000,000.00	359,000,000.00
393	Биет бус хөрөнгө	316,993,333.44	316,781,666.88
39301	Программ хангамж	2,520,000.00	1,385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,346,666.56	-423,333.12
39303	Бусад биет бус хөрөнгө	315,820,000.00	315,820,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,532,351,067.49	2,442,799,737.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	54,768,000.00	163,953,820.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,768,000.00	163,953,820.00
413	Өглөг	54,768,000.00	163,953,820.00
41320	Ажиллагсадтай холбогдсон өглөг		1,787,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	54,768,000.00	159,146,320.00
4136	Бусад өглөг		3,020,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		2,310,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		710,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,477,583,067.49	2,278,845,917.52
51	Засгийн газрын хувь оролцоо	2,477,583,067.49	2,278,845,917.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,567,962,432.24	3,567,962,432.24
51101	Өмч: - төрийн	3,567,962,432.24	3,567,962,432.24
512	Хуримтлагдсан үр дүн	-1,150,288,568.32	-1,349,025,718.29
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,150,288,568.32	-1,150,288,568.32
51220	Тайлант үеийн үр дүн		-198,737,149.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,909,203.57	59,909,203.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,532,351,067.49	2,442,799,737.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,321,734,750.00	1,786,053,421.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		90,600,321.00
120	Нийтлэг татварын бус орлого		90,600,321.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		90,600,321.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,635,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		83,965,321.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,321,734,750.00	1,695,453,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	759,145,300.00	787,402,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	759,145,300.00	787,402,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,594,350.00	233,787,300.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,480,700.00	203,797,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,896,600.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,217,050.00	29,989,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	497,995,100.00	674,263,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	497,995,100.00	674,263,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,491,584,664.04	1,977,499,862.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,491,584,664.04	1,977,499,862.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,432,786,907.79	1,942,357,253.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,858,659.32	623,053,140.22
210101	Үндсэн цалин	295,689,445.89	353,333,979.45
210102	Нэмэгдэл	124,249,863.43	161,101,237.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,510,000.00	59,904,000.00
210104	Урамшуулал	31,409,350.00	48,713,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,958,927.52	76,671,504.25
210201	Тэтгэврийн даатгал	43,485,441.01	52,754,700.52
210202	Тэтгэмжийн даатгал	5,039,486.20	6,206,435.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,869,934.83	3,103,217.68
210204	Ажилгүйдлийн даатгал	2,519,743.10	2,921,430.16
210205	Эрүүл мэндийн даатгал	10,044,322.38	11,685,720.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	496,910,525.30	729,604,245.80
210301	Гэрэл, цахилгаан	10,291,558.30	13,203,184.80
210302	Түлш, халаалт	484,517,352.00	707,970,560.00
210303	Цэвэр, бохир ус	2,101,615.00	8,430,501.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,263,551.61	22,863,011.00
210401	Бичиг хэрэг	2,421,850.00	1,896,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,121,450.00	4,921,016.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,684,101.61	2,067,505.00
210405	Хог хаягдал. Устгах цэвэрлэх	1,350,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,686,150.00	5,132,940.00
210408	Бараа материал акталсны зардал		8,244,850.00

2105	Нормативт зардал		6,770,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		6,770,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,375,150.00	49,256,900.00
210604	Урсгал засвар	24,375,150.00	49,256,900.00
2107	Томилолт, зочны зардал	7,263,000.00	3,126,000.00
210702	Дотоод албан томилолт	7,263,000.00	3,126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,561,290.00	21,471,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,907,840.00	16,021,480.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	876,000.00	1,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	119,250.00	329,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,000.00	154,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363,000.00	752,000.00
210807	Газрын төлбөр	3,158,200.00	3,014,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	313,595,804.04	409,540,692.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,836,900.00	240,909,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,114,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	169,758,904.04	162,516,792.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,797,756.25	35,142,608.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,700,103.00	26,280,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,732,131.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,037,972.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,930,000.00	26,280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,096,018.55	8,859,784.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,096,018.55	8,859,784.53
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,634.70	2,824.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,634.70	2,824.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-169,849,914.04	-191,446,441.67
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		7,290,708.30
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		7,290,708.30
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-7,290,708.30
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-169,849,914.04	-198,737,149.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,321,734,750.00	1,702,088,100.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		6,635,000.00
	Нийтлэг татварын бус орлого		6,635,000.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого		6,635,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,635,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,321,734,750.00	1,695,453,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	759,145,300.00	787,402,400.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	759,145,300.00	787,402,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,594,350.00	233,787,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,480,700.00	203,797,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,896,600.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,217,050.00	29,989,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	497,995,100.00	674,263,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	497,995,100.00	674,263,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,311,805,850.00	1,702,088,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,311,805,850.00	1,702,088,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,252,822,093.75	1,663,910,491.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,858,659.32	621,360,140.22
210101	Үндсэн цалин	295,689,445.89	353,333,979.45
210102	Нэмэгдэл	124,249,863.43	161,101,237.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,510,000.00	59,904,000.00
210104	Урамшуулал	31,409,350.00	47,020,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,021,727.52	76,671,504.25
210201	Тэтгэврийн даатгал	42,822,895.78	52,754,700.52
210202	Тэтгэмжийн даатгал	5,049,763.36	6,206,435.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,478,681.69	3,103,217.68
210204	Ажилгүйдлийн даатгал	2,334,077.35	2,921,430.16
210205	Эрүүл мэндийн даатгал	9,336,309.34	11,685,720.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	481,494,915.30	625,225,925.80
210301	Гэрэл, цахилгаан	10,291,558.30	13,203,184.80
210302	Түлш, халаалт	469,101,742.00	603,592,240.00
210303	Цэвэр, бохир ус	2,101,615.00	8,430,501.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,263,951.61	14,000,861.00
210401	Бичиг хэрэг	2,414,250.00	1,740,200.00
210402	Тээвэр шатахуун	2,746,250.00	3,646,016.00
210403	Шуудан холбоо	1,684,101.61	2,067,505.00
210405	Хог хаягдал устгах	1,350,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,069,350.00	5,947,140.00
2105	Нормативт зардал		8,360,000.00
210503	Нормын хувцас		8,360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,983,650.00	51,136,900.00
210604	Урсгал засвар	26,983,650.00	51,136,900.00
2107	Томилолт, зочны зардал	8,118,200.00	3,126,000.00
210702	Дотоод албан томилолт	8,118,200.00	3,126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,558,490.00	20,471,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,845,040.00	15,021,480.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	876,000.00	1,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	329,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,000.00	154,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	423,000.00	752,000.00
210807	Газрын төлбөр	3,158,200.00	3,014,150.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,522,500.00	243,557,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	147,522,500.00	237,443,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,114,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,983,756.25	38,777,608.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,886,103.00	28,680,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,732,131.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,037,972.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,116,000.00	28,680,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,096,018.55	9,494,784.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,096,018.55	9,494,784.53
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,634.70	2,824.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг / орон нутаг /	1,634.70	2,824.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,928,900.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,928,900.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,928,900.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	9,928,900.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,928,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,928,900.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-55,564,700.00	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөг/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,567,962,432.24	59,909,203.57	-980,438,654.28	2,647,432,981.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,567,962,432.24	59,909,203.57	-980,438,654.28	2,647,432,981.53
C07	Тайлант үеийн үр дүн			-169,849,914.04	-169,849,914.04
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,567,962,432.24	59,909,203.57	-1,150,288,568.32	2,477,583,067.49
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,567,962,432.24	59,909,203.57	-1,150,288,568.32	2,477,583,067.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,567,962,432.24	59,909,203.57	-1,150,288,568.32	2,477,583,067.49
D08	Тайлант үеийн үр дүн			-198,737,149.97	-198,737,149.97
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,567,962,432.24	59,909,203.57	-1,349,025,718.29	2,278,845,917.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	787,402,400.00	785,698,203.33	1,704,196.67	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	787,402,400.00	785,698,203.33	1,704,196.67	99.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	785,902,400.00	784,198,203.33	1,704,196.67	99.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,497,000.00	614,930,448.31	6,566,551.69	98.9
Үндсэн цалин	339,291,100.00	353,333,979.45	(14,042,879.45)	104.1
Нэмэгдэл	176,635,200.00	154,671,545.86	21,963,654.14	87.6
Унаа хоолны хөнгөлөлт	60,980,000.00	59,904,000.00	1,076,000.00	98.2
Урамшуулал	44,590,700.00	47,020,923.00	(2,430,223.00)	105.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,650,200.00	75,867,789.02	1,782,410.98	97.7
Тэтгэврийн даатгал	52,827,200.00	52,208,174.17	619,025.83	98.8
Тэтгэмжийн даатгал	6,214,900.00	6,142,138.10	72,761.90	98.8
ҮОМШӨ-ний даатгал	3,107,500.00	3,071,069.07	36,430.93	98.8
Ажилгүйдлийн даатгал	3,100,100.00	2,889,281.55	210,818.45	93.2
Эрүүл мэндийн даатгал	12,400,500.00	11,557,126.13	843,373.87	93.2
Хангамж, бараа материалын зардал	7,467,600.00	7,467,216.00	384.00	100.0
Бичиг хэрэг	1,465,300.00	1,465,200.00	100.00	100.0
Тээвэр, шатахуун	940,000.00	940,016.00	(16.00)	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,709,500.00	1,709,400.00	100.00	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон шавьж устгал ариутгал	600,100.00	600,000.00	100.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,752,700.00	2,752,600.00	100.00	100.0
Томилолт зочны зардал	896,000.00	896,000.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	896,000.00	896,000.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,287,800.00	4,933,150.00	(645,350.00)	115.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00	0.00	100.0
Аудит баталгаажуулалт	876,000.00	876,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	154,000.00	154,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	89,000.00	89,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	2,368,800.00	3,014,150.00	(645,350.00)	127.2
Бараа үйлчилгээний бусад зардал	74,103,800.00	80,103,600.00	(5,999,800.00)	108.1
Бараа үйлчилгээний бусад зардал	74,103,800.00	80,103,600.00	(5,999,800.00)	108.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	793,402,400.00	785,698,203.33	7,704,196.67	99.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	787,402,400.00	779,063,203.33	8,339,196.67	98.9
Улсын төсвөөс санхүүжих	787,402,400.00	779,063,203.33	8,339,196.67	98.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	6,000,000.00	6,635,000.00	(635,000.00)	110.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	6,635,000.00	(635,000.00)	110.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	674,263,400.00	674,260,575.80	2,824.20	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	674,263,400.00	674,260,575.80	2,824.20	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	674,263,400.00	674,260,575.80	2,824.20	100.0
Байр ашиглалттай холбоотой зардал	625,227,800.00	625,225,925.80	1,874.20	100.0
Гэрэл, цахилгаан	20,081,200.00	13,203,184.80	6,878,015.20	65.7
Түлш, халаалт	589,346,100.00	603,592,240.00	(14,246,140.00)	102.4
Цэвэр, бохир ус	15,800,500.00	8,430,501.00	7,369,999.00	53.4
Эд хогшил худалдан авах	49,035,600.00	49,034,650.00	950.00	100.0
Урсгал засвар	49,035,600.00	49,034,650.00	950.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	674,263,400.00	674,260,575.80	2,824.20	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	674,263,400.00	674,260,575.80	2,824.20	100.0
Улсын төсвөөс санхүүжих	674,263,400.00	674,260,575.80	2,824.20	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		232,631,712.14	(232,631,712.14)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		232,631,712.14	(232,631,712.14)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		205,451,712.14	(205,451,712.14)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,429,691.91	(6,429,691.91)
210102	Нэмэгдэл		6,429,691.91	(6,429,691.91)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		803,715.23	(803,715.23)
210201	Тэтгэврийн даатгал		546,526.35	(546,526.35)

210202	Тэтгэмжийн даатгал		64,297.22	(64,297.22)
210203	ҮОМШӨ-ний даатгал		32,148.61	(32,148.61)
210204	Ажилгүйдлийн даатгал		32,148.61	(32,148.61)
210205	Эрүүл мэндийн даатгал		128,594.44	(128,594.44)
2104	Хангамж бараа материалын зардал		6,533,645.00	(6,533,645.00)
210401	Бичиг хэрэг		275,000.00	(275,000.00)
210402	Тээвэр шатахуун		2,706,000.00	(2,706,000.00)
210403	Шуудан холбоо		358,105.00	(358,105.00)
210405	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл		3,194,540.00	(3,194,540.00)
2105	Нормативт зардал		8,360,000.00	(8,360,000.00)
210503	Нормын хувцас		8,360,000.00	(8,360,000.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,102,250.00	(2,102,250.00)
210604	Урсгал засвар		2,102,250.00	(2,102,250.00)
2107	Томилолт зочны зардал		2,230,000.00	(2,230,000.00)
210702	Дотоод албан томилолт		2,230,000.00	(2,230,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		15,538,610.00	(15,538,610.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		14,221,480.00	(14,221,480.00)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		292,000.00	(292,000.00)
210803	Даатгалын үйлчилгээ		329,130.00	(329,130.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		33,000.00	(33,000.00)
210806	Мэдээлэл технологийн зардал		663,000.00	(663,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		163,453,800.00	(163,453,800.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		157,339,800.00	(157,339,800.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,114,000.00	(6,114,000.00)
213	Урсгал шилжүүлэг		28,335,587.86	(28,335,587.86)
2132	Бусад урсгал шилжүүлэг		27,180,000.00	(27,180,000.00)
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		27,180,000.00	(27,180,000.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		232,631,712.14	(232,631,712.14)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		232,631,712.14	(232,631,712.14)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		202,943,207.14	(202,943,207.14)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		29,688,505.00	(29,688,505.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Биеийн тамир, спортын газар нь идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох, спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх,

тамирчдын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

Байгууллагын үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Биеийн тамир спортын тухай хуулиудыг дагаж мөрддөг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Биеийн тамир спортын тухай хуульд - 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр,
- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биеийн тамир спортын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89,551.4 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	635.0	635.0
Урьдчилгаа			
Бараа материал	52,472.2	74,828.0	22,355.8
Үндсэн хөрөнгө	2,479,878.9	2,367,336.7	-112,542.2
Нийт хөрөнгө	2,532,351.1	2,442,799.7	-89,551.4
Өр төлбөр	54,768.0	163,953.8	109,185.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,477,583.1	2,278,845.9	-198,737.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,532,351.1	2,442,799.7	-89,551.4

Авлагын дансны эцсийн үлдэгдэл 635.0 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага данс өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 74,820.0 мянган төгрөг болж 22,355.8 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 343.0 мянга, аж ахуйн материал 689.3 мянган төгрөгөөр тус тус буурч, харин бусад хангамжийн материал 1,401.0 мянга, тусгай зориулалтын материал 21,987.1 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,367,336.7 мянган төгрөг болж, 112,542.2 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт, акталж, устгасан буюу данс бүртгэлээс хассан хөрөнгө болон хуримтлагдсан элэгдлийн зардлаас голлон шалтгаалжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 109,185.8 мянган төгрөгөөр өсч 163,953.8 мянган төгрөг болсон нь санхүүжилт дутуу ирсэнтэй холбогдуулан 159,146.3 мянган төгрөгийн халаалтын зардлын өр, 94.5 мянган төгрөгийн татварын өр, 1,693.0 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон өр, 2,310.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр, 710.0 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх өр үүссэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,278,845.9 мянган төгрөг болж 198,737.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 464,318.7 мянган төгрөгөөр буюу 35.1 хувиар өссөн байна. Орлого өсөхөд засаг даргын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, төсөвт байгууллагын өөрийн орлого болон тогтмол зардлын санхүүжилт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 485,915.2 мянган төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн байна. Зарлага өсөхөд үндсэн цалин, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 971,760.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 828,209.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 5,708.0 мянган төгрөгөөр өсгөж 977,468.4 мянган төгрөгөөр баталсан байна. Орон нутгийн төсвийг төсвийн төсөлд санал өгсөн дүнгээр буюу 828,209.5 төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 338,012.1 мянган төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,467,665.8 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсвөөс 1,453,323.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,635.0 төгрөгийн орлого бүрдүүлж нийт 1,459,958.8 мянган төгрөгийн санхүүжилтаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,459,958.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг хэмнэж 8,342.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	710,998.6	703,294.6	7,704.0	98.9%
2	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	674,263.4	674,260.6	2.8	100.0%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал /80802	1,500.0	1,500.0	0	100.0%
4	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	800.0	800.0	0	100.0%
5	Үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагаа /82116/	68,435.2	67,800.1	635.1	99.1%
6	Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих /82115/	12,303.6	12,303.5	0.1	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	1,385.0	Аcoluos, Dynamic, Архивын программ зэрэг 3 программ ашигладаг.
2	Унаа, хоолны зардал	59,904.0	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 12.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	9,706.0	Тайлан онд 10 арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө батлуулан гүйцэтгэсэн байна. Үүнээс эрх этгээдээс баталсан тушаал шийдвэртэй 9,706.0 мянган төгрөгийн 3 арга хэмжээ, тушаал шийдвэргүй 7 арга хэмжээг зохион байгуулж, хамрагдсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	3,400.0	Тайлант онд "МВС" телевизрүү 1,600.0 мянга, Мөстийн оргил Медиа ХХК-д 1,800.0 мянган төгрөг тус тус гэрээ байгуулан шилжүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 203,797.9 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29,989.4 мянга, нийт 233,787.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 232,631.7 мянган төгрөгийг зарцуулж 1,155.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.7-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд спортын дэд хөтөлбөрөөс нийт 184,930.0 төгрөгийн санхүүжилт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөрөөс 8,780.0 төгрөгийн санхүүжилт, аялал жуулчлалыг дэмжих хөтөлбөрөөс 2,000.0 төгрөгийг тус тус авч хэрэгжүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Биеийн тамир, спортын газар нь тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хангамж бараа материалын зардал болох бичиг хэрэг, тээвэр шатахуун, аж ахуйн материал, тусгай зориулалтын материалд нийт 76,105.4 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,491,584.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,915.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,932.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,977,499.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 19,775.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 15,820.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 168, хугацаа хоцроосон мэдээлэл 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,846.5 мянган төгрөгийн шатах, тослох материалыг зарцуулахдаа олгосон жагсаалт үйлдээгүй, замын хуудсыг дутуу хөтөлсөн, зарцуулалтын тооцоо бодоогүй 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг Биеийн тамир, спортын газрын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/93 дугаар албан бичгээр “Баян жанжин хишиг” ХХК-д ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр